

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД,
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2024 оны __ сарын ... өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Жолоочийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хууль зүй, дотоод хэргийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 2012 оны А/23/24 тоот тушаалаар баталсан “Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх болон түр хугацаагаар орж ирж байгаа авто тээврийн хэрэгсэл эзэмшигч, өмчлөгчийг жолоочийн даатгалд хамруулах журам”-д дор дурдсан агуулга бүхий 2.7 дахь заалтыг нэмсүгэй:

“2.7.Санхүүгийн зохицуулах хороо нь хилийн зурвас (боомт) дахь даатгалын зуучлалын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар Хил хамгаалах байгууллагыг мэдээллээр хангана.”

2. Мөн журмын 2.1, 2.2, 2.3, 2.4, 2.6 дахь заалтыг дор дурдсанаар тус тус өөрчлөн найруулсугай:

“2.1.Улсын хилээр нэвтэрч байгаа авто тээврийн хэрэгсэл эзэмшигч, өмчлөгчийг жолоочийн даатгалд хамруулах үйл ажиллагааг хилийн зурвас (боомт)-т хилийн цэргийн ангиас тогтоон өгсөн хэсэгт зохион байгуулна.”

“2.2.Даатгалын зуучлагч компани нь хилийн зурвас (боомт)-т үйл ажиллагаа явуулахдаа Монгол Улсын Хилийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2.3-т заасны дагуу Хил хамгаалах байгууллагаас зөвшөөрөл авна.”

“2.3.Улсын хилийн халдашгүй байдлыг хангах, хилийн бүсэд мөрдөх журмыг хэрэгжүүлэхийг тулд авто тээврийн хэрэгсэл эзэмшигч, өмчлөгчийг Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх, түр хугацаагаар улсын хилээр нэвтрэх тухайн боомтын чиглэлд даатгалд хамруулах үйл ажиллагааг даатгалын зуучлагч компани явуулна.”

“2.4.Даатгагч, даатгуулагчийн эрх ашгийг хангах зорилгоор хилийн зурвас (боомт)-т үйл ажиллагаа явуулах даатгалын зуучлагч компани нь 3 буюу түүнээс дээш даатгалын компанийг төлөөлж, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалыг хийнэ.

“2.6. Хилийн зурвас (боомт)-т үйл ажиллагаа явуулж буй даатгалын зуучлагч компани нь хилийн зурваст мөрдөх журмыг хэрэгжүүлэх, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, хилийн тухай бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой хилчдийн тавьсан шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.”

3. Мөн журмын 2.5 дахь заалтыг хассугай.

4.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яам /.../, Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын алба /Т.Жамбаажамц/-д тус тус даалгасугай.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

Б.ЭНХБАЯР

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГА

Д.БАЯРСАЙХАН